

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/027/НА-СТА-ТЭЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2025 он

Монгол Улсын Ерөнхий Аудиторын орлогч: Я.Самбууням  
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn  
Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Долгорсүрэн  
Утас: 261740 Цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn  
Ахлах аудитор: П.Амарсанаа  
Утас: 261740 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn  
Аудитор: Ж.Мөнхтуул  
Утас: 261740 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn  
Аудитор: Н.Нямсүрэн  
Утас: 261740 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА Л.ЦЭДЭВСҮРЭН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2025.04.25 № 1604

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн нэгтгэсэн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах, томилох үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтад 16 яам, 21 аймгийн Засаг даргын Тамгын газар, түүний эрхлэх асуудлын хүрээний бүх агентлаг зэрэг 499 төрийн байгууллагын 10588 албан хаагчийг хамруулсан бөгөөд өмнөх оноос томилгооны зөрчлийн тоо 3.6 хувиар буурсан, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлсэн дүн 3 дахин өсөж, 2024 онд 623.4 сая төгрөгийг буруутай албан тушаалтан, иргэнээр төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим системийг өргөжүүлэн “Байгууллагын бүтэц, албан тушаалын тодорхойлолт”, “Хяналт, үнэлгээ”, “Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт”, “Төрийн албан хаагчын оролцоо” зэрэг 4 модулийг данс бүртгэлд тусган, Төрийн албаны тайлангийн Dashboard, Open-Exam шалгалт, Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг 3 дэд системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн албаны хаагчийн ёс зүйн хуулийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр баталсан бөгөөд тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Ёс зүйн хороо нь Төрийн албаны төв байгууллагын дэргэд ажиллах бөгөөд ёс зүйн асуудал хариуцсан нэгжтэй байна" гэж заасан боловч Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.35, 4.1.36, 4.1.38, 14 дүгээр зүйлийн 14.1, 16 дугаар зүйлийн 16.4 дэх заалттай нийцүүлэхгүйгээр Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор "Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм"-ийн 4.5-д "Ажлын албаны дарга нь Хорооны төсвийн шууд захирагч байх бөгөөд Ажлын албаны дотоод журмыг тогтооно", 6.1-д "Хорооны дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. 6.1.4-т Хорооны төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх" гэж баталсан, зарим заалтууд бусад хууль, эрх зүйн актад нийцэхгүй байгаагаас шалтгаалан хорооны гишүүдийн цалин, урамшууллыг хэрхэн олгох асуудал тодорхойгүй байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

 Д.ЗАГДЖАВ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	358,742.5	169,384.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	280,842.0	97,207.9
33	АВЛАГА	1,140.5	0.0
34	УРЬДЧИЛГАА	0.0	9,400.0
35	БАРАА МАТЕРИАЛ	76,760.1	62,776.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,185,252.2	2,507,627.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,185,252.2	2,507,627.3
39200	Биет хөрөнгө	885,534.4	949,979.0
39300	Биет бус хөрөнгө	1,299,717.9	1,557,648.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,543,994.7	2,677,012.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	268,290.9	19,325.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	268,290.9	19,325.0
41300	Өглөг	268,290.9	19,325.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,275,703.8	2,657,687.0
51	Засгийн газрын хувь оролцоо	2,275,703.8	2,657,687.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	434,739.6	434,739.6
51200	Хуримтлагдсан үр дүн	1,840,094.7	2,222,077.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	869.5	869.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,543,994.7	2,677,012.0

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан /мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,149,402.2	8,725,172.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,150.0	856,296.8
120	Нийтлэг татварын бус орлого	10,150.0	856,296.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,139,252.2	7,868,875.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,772,790.9	8,268,166.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,772,790.9	8,268,166.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,268,540.2	6,676,547.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,748,940.0	3,895,690.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	215,706.8	473,172.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,995.5	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	129,362.1	190,854.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,106.3	9,890.0
2107	Томилолт, зочны зардал	14,541.5	69,430.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	588,567.9	1,273,610.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	533,320.2	763,899.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	504,250.7	1,591,619.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	376,611.3	457,005.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	75,022.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	376,611.3	381,983.2

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан /мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,460,277.2	8,585,833.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	321,025.0	716,958.2
120	Нийтлэг татварын бус орлого	321,025.0	716,958.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,139,252.2	7,868,875.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,471,264.6	7,998,676.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,471,264.6	7,998,676.7

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,899,676.2	6,407,056.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,688,500.6	3,898,812.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	244,971.7	483,453.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,995.5	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	130,406.0	146,650.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,106.3	12,921.8
2107	Томилолт, зочны зардал	15,741.5	69,430.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	588,567.9	1,287,666.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	193,386.7	508,121.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	571,588.4	1,591,619.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	989,012.6	587,156.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	761,378.8	770,790.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	761,378.8	770,790.8
2200	Дотоод эх үүсвэрээр	761,378.8	770,790.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-761,378.8	-770,790.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	227,633.7	-183,634.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	53,208.2	280,842.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	280,842.0	97,207.9

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	434,739.6	869.5	1,456,839.7	1,892,448.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	6,643.7	6,643.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	434,739.6	869.5	1,463,483.4	1,899,092.5
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	376,611.3	376,611.3
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	434,739.6	869.5	1,840,094.7	2,275,703.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	434,739.6	869.5	1,840,094.7	2,275,703.8
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	434,739.6	869.5	2,222,077.9	2,657,687.0

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,554,857,900.00	6,660,288,933.01	894,568,966.99	88.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,554,857,900.00	6,660,288,933.01	894,568,966.99	88.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,401,118,200.00	6,568,849,805.01	832,268,394.99	88.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,322,895,600.00	3,898,812,868.99	424,082,731.01	90.2
210101	Үндсэн цалин	2,626,512,400.00	2,554,639,678.36	71,872,721.64	97.3
210102	Нэмэгдэл	992,923,000.00	788,765,323.46	204,157,676.54	79.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	334,643,700.00	291,760,187.96	42,883,512.04	87.2

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210104	Урамшуулал	353,816,500.00	248,647,679.21	105,168,820.79	70.3
210105	Гэрээт ажлын хөлс	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	563,177,500.00	483,453,811.85	79,723,688.15	85.8
210201	Тэтгэврийн даатгал	370,644,100.00	332,695,318.27	37,948,781.73	89.8
210202	Тэтгэмжийн даатгал	48,134,600.00	39,064,745.89	9,069,854.11	81.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,067,200.00	19,771,697.51	4,295,502.49	82.2
210204	Ажилгүйдлийн даатгал	24,067,300.00	17,522,456.24	6,544,843.76	72.8
210205	Эрүүл мэндийн даатгал	96,264,300.00	74,399,593.94	21,864,706.06	77.3
2104	Хангамж, бараа материалын зардал	152,585,600.00	144,611,762.81	7,973,837.19	94.8
210401	Бичиг хэрэг	34,679,800.00	34,648,850.00	30,950.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	43,542,800.00	42,403,567.00	1,139,233.00	97.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,164,200.00	33,848,789.81	3,315,410.19	91.1
210404	Ном, хэвлэл	10,817,700.00	10,816,200.00	1,500.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,381,100.00	22,894,356.00	3,486,744.00	86.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	317,581,400.00	311,037,690.00	6,543,710.00	97.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	294,414,100.00	288,867,590.00	5,546,510.00	98.1
210602	Тавилга	12,330,900.00	12,280,150.00	50,750.00	99.6
210604	Урсгал засвар	10,836,400.00	9,889,950.00	946,450.00	91.3
2107	Томиллолт, зочны зардал	44,283,800.00	44,062,550.00	221,250.00	99.5
210702	Дотоод албан томиллолт	44,283,800.00	44,062,550.00	221,250.00	99.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,565,123,500.00	1,432,429,082.36	132,694,417.64	91.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	555,368,400.00	486,845,082.36	68,523,317.64	87.7
210803	Даатгалын үйлчилгээ	137,500.00	135,830.00	1,670.00	98.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	533,200.00	512,600.00	20,600.00	96.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	999,252,400.00	935,118,570.00	64,133,830.00	93.6
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,810,000.00	9,795,000.00	15,000.00	99.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	435,470,800.00	254,442,039.00	181,028,761.00	58.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	148,261,800.00	82,066,990.00	66,194,810.00	55.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	287,209,000.00	172,375,049.00	114,833,951.00	60.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,739,700.00	91,439,128.00	62,300,572.00	59.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	153,739,700.00	91,439,128.00	62,300,572.00	59.5
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,405,000.00	1,800,000.00	605,000.00	74.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	138,977,400.00	79,669,098.00	59,308,302.00	57.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,357,300.00	9,970,030.00	2,387,270.00	80.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,554,857,900.00	6,660,288,933.01	894,568,966.99	88.2

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,554,857,900.00	6,660,288,933.01	894,568,966.99	88.2
310001	Улсын төсвөөс санхүүжих	7,554,857,900.00	6,660,288,933.01	894,568,966.99	88.2
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	100.0
610001	Төсвийн байгууллага	2	2	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	85	67	18	78.8
620001	Удирдах ажилтан	12	12	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	73	55	18	75.3
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	85	67	18	78.8
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	73	56	17	76.7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	2	1	66.7
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9	9	-	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан** /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		374,807,905.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		374,807,905.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		344,362,196.50
2104	Хангамж, бараа материалын зардал		3,838,320.50
210402	Тээвэр, шатахуун		296,213.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,602,107.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,940,000.00
2107	Томилолт, зочны зардал		25,367,904.00
210702	Дотоод албан томилолт		25,367,904.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		315,155,972.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		315,155,972.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		30,445,708.50
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		30,445,708.50
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		30,445,708.50
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		374,807,905.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		374,807,905.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		374,807,905.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 50.5 сая төгрөгийн зөрчлийг<sup>1</sup> илрүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 50.5 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 32.9 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй дүгнэлт” өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 580.6 сая төгрөгийн 7 зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар зөвлөмжийг хүргүүлээ.

#### Зөвлөмж

##### 3.1 Санхүүгийн тайлантай холбоотой зөвлөмж

###### 1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 9 нэр төрлийн 49.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, дахин үнэлгээ хийгээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг цаг тухай бүрт холбогдох байгууллагын шийдвэрийг гаргуулж, дахин үнэлгээ хийлгэн, данс бүртгэлд үнэн зөв тусгаж байх.

###### 2. Татварын тайлантай холбоотой

Илрүүлэлт. Хувь хүний орлогын албан татварын тайланд албан хаагчдаас суутгасан 0.7 сая төгрөгийг дутуу тусгаж, төсөвт төлөөгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19-д “суутган төлөгч гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчдаас суутгасан татварыг хувь хүний орлогын албан татварын тайланд тухай бүр тайлагнаж, төсөвт төвлөрүүлж байх

##### 3.2 Нийцлийн асуудалтай холбоотой зөвлөмж

###### 1. Худалдан авах ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт. Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж батлуулаагүй, багцалж харьцуулалтын аргаар худалдан авах боломжтой хөрөнгийн төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулан худалдан авсан дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Төрийн албаны зөвлөл тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, батлуулаагүй нийт 120.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. Үүнээс: Багцалж харьцуулалтын аргаар худалдан авах боломжтой 79.4 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг 4 аж ахуй нэгж, байгууллагаас шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Ёс зүйн хороо тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж батлуулаагүй нийт 67.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. Үүнээс: Багцалж харьцуулалтын аргаар худалдан авах боломжтой 45.2 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг 4 аж ахуй нэгж, байгууллагаас шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид худалдан авах ажиллагааг бүрэн төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж, баталсан төлөвлөгөөний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримтлан, хуульд заасан аргачлалын дагуу зохион байгуулж ажиллах.

### *2.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой*

**Илрүүлэлт:** Тайлант оны эцэст нэр бүхий 3 албан хаагчид 1 сарын үндсэн цалингийн 100.0 хувиар, 1 албан хаагчид 1 сарын үндсэн цалингийн 150.0 хувиар тооцож, нийт 13.2 сая төгрөгийн урамшууллыг улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, албан хаагчид урамшууллыг давхардуулан олгохгүй байх, төсвийг хэмнэлттэй зарцуулах зөвлөмж өгөв.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

### *3.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой*

**Илрүүлэлт:** Тайлант онд Төрийн албаны зөвлөл 100.5 сая төгрөгийн 7 зарлагын гүйлгээ, Ёс зүйн хороо 51.9 сая төгрөгийн 9 зарлагын гүйлгээний мэдээллийг шилэн дансны мэдээллийн цахим системд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг хуульд заасан хугацаанд тухай бүр мэдээлж байх зөвлөмж өгөв.

### *4. Урамшуулалтай холбоотой*

**Илрүүлэлт:** Төрийн албаны хаагчийн ёс зүйн хуулийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр баталсан бөгөөд тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Ёс зүйн хороо нь Төрийн албаны төв

байгууллагын дэргэд ажиллах бөгөөд ёс зүйн асуудал хариуцсан нэгжтэй байна" гэж заасан боловч Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.35, 4.1.36, 4.1.38, 14 дүгээр зүйлийн 14.1, 16 дугаар зүйлийн 16.4 дэх заалттай нийцүүлэхгүйгээр Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор "Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм"-ийн 4.5-д "Ажлын албаны дарга нь Хорооны төсвийн шууд захирагч байх бөгөөд Ажлын албаны дотоод журмыг тогтооно", 6.1-д "Хорооны дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. 6.1.4-т Хорооны төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх" гэж баталсан байна.

Ёс зүйн хорооны гишүүдийн цалин, урамшууллыг хэрхэн олгох асуудал тодорхойгүй байгаагаас шалтгаалан тайлант онд 9 гишүүнд олгох урамшууллыг баталсан цалингийн сангаас бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд шилжүүлэх хүсэлтийг 3 удаа гарган төсвийн зохицуулалт хийж, нийт 268.0 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5-т "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрмийг Төсвийн тухай хуульд нийцүүлэх арга хэмжээг авч, хорооны гишүүдэд олгох цалин, урамшууллыг хууль, журамд нийцүүлэн олгох асуудлыг дүрэмд тодорхой тусган төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн батлуулж, баталсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулахыг зөвлөж байна.

#### **5. Ахмадын сантай холбоотой**

**Илрүүлэлт:** Тайлант оны төсвийн төсөлд тусгаж, төлөвлөхгүйгээр төсвийн хэмнэлтээс 74.3 сая төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн байна.

Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14.7-д "... байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулна", Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын 1.3-т "төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Тайлант жилийн хэмнэсэн зардлыг ахмадын санд төвлөрүүлэхдээ тухай жилийн төсөвт төлөвлөж, батлуулж ажиллахыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 50.5 сая төгрөгийн зөрчлийг<sup>2</sup> илрүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж хүргүүлсэн.

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн албаны зөвлөл	2	50.5	0	-	0	-	2	50.5	-	-	-	-
<b>Нийт</b>	<b>2</b>	<b>50.5</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>50.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 580.6 сая төгрөгийн 7 зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар зөвлөмжийг хүргүүллээ.

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төрийн албаны зөвлөл	1	100.5					1	100.5
Ёс зүйн хороо	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>100.5</b>					<b>2</b>	<b>100.5</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн албаны зөвлөл	2	153.7					2	153.7

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Ёс зүйн хороо	3	326.4					3	326.4
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>480.1</b>					<b>5</b>	<b>480.1</b>
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>580.6</b>	-	-			<b>7</b>	<b>580.6</b>